

2010 оны 2-3 дугаар сар

Дугаар 6

Эрхэм уншигч танд

МАЖ үүсгэн байгуулагдаад богинохон хугацаанд олон гишүүд дэмжигчидтэй болж, олны хүч дэмжлэгээр үйл ажиллагаагаа амжилттай явуулж байна.

Санхүүгийн жил удахгүй дуусаж, МАЖ-ийн үйл ажиллагаа, төлөвлөгөөг хэлэлцэж шийдэх МАЖ-ийн Нэгдсэн хурал 5 дугаар сард болно. МАЖ-ийн үндсэн гишүүнээр элссэнээр та бүхэн МАЖ-ийн удирдах зөвлөлийг сонгох, сонгогдох, үйл ажиллагааны төлөвлөгөө төсөв зэрэг асуудлаар санал өгөх эрхтэй юм. Энгийн гишүүд, дэмжигчид ч МАЖ-д өөрсдийн санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжтой. МАЖ зөвхөн цөөн хэдэн хүний байгууллага бус харин та бидний оролцоо, идэвх санаачилгаар цэнэглэгдэж, үйл ажиллагааны цар хүрээ тэлж, хөгжин «Япон дахь монголчуудын нэгдэж ажиллах талбар» болно.

Иймээс та бүхэн МАЖ-д илэрхийлэх хүсэлтээ info@maj.mn хаягаар илгээгээрэй.



МАЖ-ийн хамт олон

Канагава иргэдийн үйл ажиллагаа Фейр 2010 “Талын Салхи” МАЖ

Өнгөрсөн амралтын өдрүүдэд (3 сарын 13,14) Ёкохама хотын Канагава Төвд болсон “Иргэдийн үйл ажиллагаа Фейр 2010”-т Монголчуудын Холбоо Япон (МАЖ <http://www.maj.mn/>) анх удаагаа амжилттай оролцож өндөрлөлөө. “Талын салхи” сэдвийн дор хамтрагч байгууллагуудынхаа хүч туслалцаатайгаар, сэтгэл, зүтгэлээ нэгтгэж Канагава аймаг, Ёкохама хотын иргэд, олон нийтийн байгууллагуудад Монгол эх орноо болон өөрсдийн байгууллагаа үйл ажиллагаатай нь илүү ойр гүн гүнзгий танилцуулж бусад байгууллагуудаас суралцах, харилцан туршлага солилцох зэргээр хамтын ажиллагааныхаа эх суурыг тавьж чадсан гэдэгтэй итгэлтэй байна.

“Талын Салхи” хөтөлбөртөө Монгол орноо танилцуулах булан ажиллуулж, фото үзэсгэлэн, товхимол, видео үзүүлж монгол дээлээрээ гоёсон цоглог залуус бүсгүйчүүд япон иргэдэд дэлгэрэнгүй тайлбар хийхийн зэрэгцээ МАЖ-ын зөвшүүн Б.Хүрэлтогоо хуучин монгол үсгээр хүмүүст нэрийг нь уран бичлэгээр бичиж дурсгах, Хуурч хөөмийч

Гарчиг:

МАЖ-ийн Цагаан сар

1

Канагава фэйр

2



МАЖ-ийн гишүүнчлэл

Үндсэн гишүүн: -Бүртгэлийн дэлгэрэнгүй хуудсыг бөглөж, жилийн хураамж 10,000 иенийг төлснөөр үндсэн гишүүн болно.

Үндсэн гишүүн холбооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, саналаа илэрхийлэх, хяналт тавих, нэгдсэн хуралд оролцож, тэргүүн болон удирдах зөвлөлийн гишүүдийн сонгуульд оролцох, нэр дэвших, дэвшүүлэх, холбооноос эрхлэн гаргах бүх төрлийн мэдээлэл, хурлуудын тайлан, санхүүгийн тайлан зэргийг байнга хүлээн авах, байгууллагаас зохион байгуулах баяр ёслол болон бусад төрлийн үйл ажиллагааны үеэр тусгай хөнгөлөлт эдэлнэ.

Энгийн гишүүн: -Овог нэр, мэйл хаяг зэрэг товч мэдээллээ ирүүлж, жилийн хураамж 2,000 иенийг төлснөөр бүртгэгдэнэ. Энгийн гишүүн нь холбооны мэйлийн сүлжээнд хамрагдаж Холбооноос гаргах мэдээллүүд, мөн гишүүд хоорондоо солилцох мэдээллээс байнга хүлээн авах, байгууллагаас зохион байгуулах баяр ёслол болон бусад төрлийн үйл ажиллагааны үеэр тодорхой хэмжээний хөнгөлөлт эдэлнэ.

КАНАГАВА ИРГЭДИЙН ФЭЙР 2010

Б.Болдэрдэнэ талын салхийг дуудах мэт уянгалуулан исгэрүүлэх нь тэр орчимдоо монгол ахуйг бүрэн цогцлоож үзэгчидийн нүд сэтгэлийг эрхгүй татаж байлаа. Энэ тухай ердөө маргш өдөр нь Канагава комюнити сайт дээр мэдээлсэн байлаа. (<http://news.kanaloco.jp/localnews/article/1003140014/>)

Монголын байгаль-хүнийг дээдлэн эрхэмлэхийг зорилго болгодог бидний хамтрагч Meet the Smiles сайн дурын байгууллагынхан (<http://www.meet-the-smiles.com/>) өөрсдөө дизайныг гаргаж монгол дахь тахир дутуу болон өнчин ядуу хүмүүсээр гар аргаар хийлгэж авчирсан эсгий эдлэлийн “Heart of Mongolia”(<http://heartofmongolia.shop-pro.jp/>) дээж өнгө үзэмжээрээ аргагүй олны анхаарлыг татаж байв. Тэрээр “Fair-Trade” хэлбэрийн энэ үйл ажиллагаагаар олсон ашгаасаа монголын асрамжийн газраас гарч оюутны ширээнд сууж буй дүү нарт маань сургалтын тэтгэлэг болгон хандивладаг ажээ. Мөн энэ буланд тавигдсан Алтай кашмер компан (www.altaicashmere.mn) ын бүтээгдхүүний дээж монгол ямааны ноолуурын өнгө чанарыг гайхуулж байлаа.

МАЖ орон нутгийн иргэдэд өөрсдийн үйл ажиллагааг сурталчилахаас гадна Япон дахь Монгол Оюутны Холбоо (ЯМОХ <http://www.yamoh.org/>) ны дүү нарыгаа татан оролцуулж тэдний жил бүр зохион байгуулдаг “Хаврын баяр” наадмыг сурталчилж идэвхтэй хамтран ажиллав.

Puro Enterprise Corporation.-нд ажилладаг авъялаг продюсер Төгөлдөр маань өөрийн найруулж хийсэн “Сүхийн цагаан морь” хүүхэлдэйн киногоо япон хэл дээр үзүүлж монгол япон хүүхдүүд нам ширтэн сууж үзэх өхөөрдөм.

Үүнээс гадна бид монгол давсаар амталсан бууз, сүүтэй цайгаар ирсэн зочидоо дайлж монгол амтыг мэдрүүлсэн нь олон япон хүний таашаалд нийцэж байсан нь гараа гаргаж хийсэн бидэнд өгсөн том урам шагнал байлаа. Учир нь япон хүмүүсийн аманд тохируулж буудайн тос, байцаа, жууцайгаар амталсан бидний хөдөлмөр зүтгэлийг үнэлсэн хэрэг байлаа. Бууз хийхэд МАЖ-ын гишүүдээс гадна тэдний гэр бүл, найз нөхөд, МАЖ-ыг дэмжигч олон сайхан залуус бужигнаж багахан наадмыг дайтай уулзаагүй удсан найз нөхөд сонин сайхнаасаа хуучилж инээд хөөрөөр дүүрэн сайхан үйл явдал болж өндөрлөлөө.

Дэм дэмэндээ, дээс эрчиндээ гэдэг, цаашид бид хамтран дурсамж дүүрэн олон сайхан үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж чадна гэдэгт итгэл дүүрэн байна.

МАЖ, Удирдах Зөвлөл

Зохион байгуулах хэсгийн ахлагч Ч.Баасандаш

Хамтран оролцогчид: ЯМОХ-ын хамт олон, Meet the Smiles NPO, Хуурч хөөмийч Б.Болд-Эрдэнэ, МАЖ болон МАЖ хүүхэд багын гишүүд, Алтай Кашмер компани



Хөөмийч С.Болд-Эрдэнэ морин хуурын эгшиг, хөөмийн эгшигээр хурсан олны сонорыг мялаалаа



ЯМОХ-ийн залуус Монгол орноо сурталчилж, идэвхтэй хамтран ажиллацгаалаа.



Арын албаныхан



МАЖ-ийн монгол хоолны булан



Монгол цайгаар ирсэн хүмүүсийг дайлж байлаа

МАЖ-ийн Цагаан Сар

2010 оны 2-3 дугаар сар
Дугаар

Тийн урвагч хэмээх төмөр бар жилийн шинийн нэгэнд буюу 2010 оны 2 дугаар сарын 14-нд МАЖ-ийн хамт олон, гэр бүл, үр хүүхдүүд, найз нөхдөөрөө уулзан золгоцгоож амар мэндээ мэндэлцэн, үгийн сайныг хэлэлцэн, үйлсийн дээдийг ерөөн нэгэн өдрийг хамтдаа өнгөрөөлөө.



Ууцны оронд ХОРХОГ!

МАЖ-ийнхан бүгдээрээ хамтдаа бууз саладаа хийцгээж, халуун дотно яриаг өрнүүлэн байлаа.



Хоол унд ч бэлэн болж, өргөн золголт өрнөлөө.



МАЖ байгуулагдаад удаагүй ч улам өнөр өтгөн болж, анд найзын холбоо нөхөрлөл зузааран, шинэ найз, шинэ мэдлэг туршлага олох талбар болж байна.



Хойтон жилийн цагаан сараар улам олуулаа болж, амжилт бүтээлээр дүүрэн уулзалдан учрахын ерөөл дэвшүүлье.

